# АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙ БИЕЛЭЛТ
/2020 оны жилийн эцсээр/

2020 оны 12 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

| № | Хөтөлбөр/ төслийн агуулга | Гүйцэтгэл |
|---|---|---|
| 1. | Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар /Жич: уялдаа холбоо бүхий дэд/ төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана/<br>Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, УИХ-ын 2016 оны 51 дүгээр тогтоол", " "Авлигатай тэмцэх нийслэлийн хөтөлбөр" НИТХ-ын 2015 оны 23/01 дүгээр тогтоол 33 | Төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, иргэний нийгэм, улс төрийн нам, бүлгийг авилгыг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл , санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино. |
| 2. | Санхүүжилтийн эх үүсвэр | Улсын төсөв / зээл буцалтгүй тусламж/<br>Улсын болон орон нутгийн төсөв<br>Олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламжийн хөрөнгө, бусад эх үүсвэр |
| 3. | Хэрэгжүүлэгч байгууллага / хэрэгжих хугацаа/ | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага<br>Авлигатай тэмцэх газар |
| 4. | | Хамтран хэрэгжүүлэгч байгууллага<br>3Г, Яам агентлаг, Нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага |
| 5. | Төсөл, хөтөлбөрийн зорилтууд | Зорилт 1: Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авилгын эрсдлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинэхэн албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөлөөс ангид мэдлэг боловсрол суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх;<br>Зорилт 2: Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх;<br>Зорилт 3: Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх;<br>Зорилт 4: Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх,<br>Зорилт 5: Шүүх, эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, авилгын эсрэг хамтын ажиллагааг сайжруулах; |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | Зорилт 6: Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх;<br>Зорилт 7: Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвхи санаачилгыг дэмжих;<br>Зорилт 8: Иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах, хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх;<br>Зорилт 9: Улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагыг улс төр, биенесийн бүлэглэлийн хууль бус ашиг сонирхол, нөлөөллөөс ангид байлгах;<br>Зорилт 10: Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авилгын эсрэг боловсролыг дээшлүүлэх;<br>Зорилт 11: Авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын байгууллагын санал, зөвлөмжийг авч хэрэгжүүлэх; | |
| 5. | Зардал, Төсөв /нийт шаардагдах зардал/ | | - | |
| | Зардал | | - | |
| | Үүнд: | Төсөв/ он/ | Гүйцэтгэл | Хувь |
| | Багц 1 | 2019 он 200 000 | | 80% |
| | Багц 2 /гм/ | | - | - |
| 6. | Төсөл хөтөлбөрийн зорилт | | | |
| | 1-р зорилтын хүрээнд:<br>Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ: | | Тус газраас 2 сул орон тоо гарсныг 2019 оны 05 дугаар сарын 23-ны өдөр 01/278, 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01/46 тоот албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд тус тус хүргүүлэв. Сул орон тоог Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ны дагуу түр орлон гүйцэтгүүлэн ажиллаж байна.<br>2020 оны 05 дугаар 22-ны өдөр Төрийн албан зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөл холбогдох журмын дагуу зарлаж, Соёлын хэлтсийн даргын сул орон тоог тусгай шалгалтын сонгон шалгаруулалтаар нөхөж томилсон. Захиргаа удирдлагын хэлстийн даргын албан тушаалыг нөхөх сонгон шалгаруулалтыг хуулийн хугацаанд Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд сонгон шалгаруулалт зарлахаар захиалга хүргүүлсэн. Үүнд:<br>Тус газраас 2020 оны жилийн эцсийн байдлаар 1 сул орон тоо гарсаныг 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01/46 тоот, 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 01/144 тоот албан бичгээр, 2020 оны 08 дугаар сарын 13-ны өдөр Erp.ulaanbaatar.mn цахим хуудсаар, 2020 оны 11 дүгээр сарын 24-ний 01/242 тоот албан бичгээр тус тус Төрийн | |

| | | |
|---|---|---|
| | | албаны зөвлөлийн нийслэл дэх салбар зөвлөлд тус тус хүргүүлэв. Сул орон тоог Төрийн албаны тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ны дагуу 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдрөөс одоог хүртэл түр орлон гүйцэтгүүлэн ажиллаж байна. |
| | 2-р зорилтын хүрээнд:<br>Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх | Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.3.5-д заасан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтыг тогтмолжуулж, үр дүнг тооцох, хяналт тавих тогтолцоог бий болгож, нээлттэй засаглалын бодлогыг хэрэгжүүлэх" зорилтын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/1212 дугаар захирамжаар "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтыг зохион байгуулах журам" батлагдсны дагуу "UB ERP" дотоод удирдлагын системийн Өргөдөл гомдлын дэд систем дэх уулзалт цэсэнд бүртгэж шийдвэрлэж байна.<br>Үүнтэй холбогдуулан байгууллагад хандаж ирсэн иргэдийн хүсэлтийг хүлээн авч, шуурхай шийдвэрлэх үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, нийслэлээс гаргасан бодлого, шийдвэрт иргэдийн санал, бодлыг тусгах, ил тод байдлыг бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэн өргөдөл, гомдлыг бүртгэж шийдвэрлэх "UB ERP" дотоод удирдлагын систем дэх дэд системд бүртгэн шилжүүлж, шийдвэрлэн, системийн ашиглалтыг сайжруулан ажиллаж байна.<br>Тус газарт Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаар дамжуулан санал хүсэлт ирснийг хугацаанд нь шийдвэрлэж ажилласан. |
| | 3-р зорилтын хүрээнд:<br>Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх; | Шилэн дансны тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 384 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу мэргэжилтэн, нягтлан бодогч нар өөрийн хариуцсан мэдээллийг цаг хугацаанд нь байршуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд оруулаагүй мэдээлэл байхгүй болно. Тайлант хугацаанд тус газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, 2020 оны төсвийн төлөвлөгөө, 2020 төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээлэгдэж, тайланг журмын дагуу тус тус байгууллагын цахим хуудас, www.shilendans.gov.mn сайт, шилэн дансны самбарт байршуулж, олон нийтэд мэдээллийг хүргэн төсөв, санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллаж байна. Монгол Улсын "Шилэн дансны тухай" хууль, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох" журамд заасны дагуу тайлант хугацаанд багтаан www.shilendans.gov.mn вэб хуудас болон байгууллагын шилэн дансны самбарт байрлуулж олон нийтэд мэдээллийг хүргэн төсөв, санхүүгийн ил тод байдлыг хanган ажилласан.Тус газар болон түүний харьяа байгууллагын төсвийн гүйцэтгэлийн сарын тайлан мэдээг авч, төсвийн шууд захирагчид танилцуулан, мэдээллийн самбар болон цахим хуудсанд байрлуулан мэдээллийг иргэд, байгууллагад чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлэн ажилласан. |

| | | |
|---|---|---|
| | 4-р зорилтын хүрээнд:<br>Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх, | Худалдан авах ажиллагааны хууль, тогтоомжийн дагуу байгууллагын албан хаагчдын мэдлэг мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх, чадавхыг нь сайжруулах чиглэлээр Худалдан авах ажиллагааны А3 сертификат олгох сургалтад 3 албан хаагчийг хамруулсан.<br>Тус газрын http://nsug.ub.gov.mn цахим хуудсаар хэрэгжүүлсэн ажил, мэдээ мэдээллийг цаг тухайд нь нээлттэй мэдээлж, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангаж ажилласан. Цахим мэдээ мэдээллийн нээлттэй байдал, хүртээмжийн талаар улирал тутам санал асуулга явуулж байна. Байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийн баазыг www.ub1234.mn цахим хуудсаар, Нийслэлийн нутгийн өөрөө удирдах байгууллага болон нутгийн захиргааны байгууллагуудын шийдвэрийн нэгдсэн сангийн http://www.ublegal.mn/ вэб цахим хуудас, шилэн дансны http://www.ublegal.mn/ сайтад тогтмол байршуулж хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллаж байна.<br>Мөн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээ, үйл ажиллагааны мэдээллийг байгууллагын http://nsug.ub.gov.mn вэб хуудсаар мэдээллийн санд тогтмол байршуулж байна. |
| | 5-р зорилтын хүрээнд:<br>Шүүх, эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, авлигын эсрэг хамтын ажиллагааг сайжруулах; | Нийслэлийн Соёл, урлагийн газраас харьяа соёл, урлагийн байгууллагуудын албан хаагчдад зориулан “Төрийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй” сэдвээр болон Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комисстой хамтран “Хүний эрх”, “Жэндэр”, “Хүний соёлын эрхийг хангахад соёл, урлагийн салбарын төрийн байгууллагын үүрэг оролцоо” сэдвээр сургалтыг 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн байранд зохион байгуулсан. Тус газрын харьяа соёлын байгууллагын нийт 30 гаруй албан хаагчид хамрагдав. |
| | 6-р зорилтын хүрээнд:<br>Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх; | Тус газар нь Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэн холбогдох хууль, тогтоомжийг мөрдлөг болгон ажиллаж байна. |
| | 7-р зорилтын хүрээнд:<br>Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвхи санаачилгыг дэмжих; | Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвхи санаачилгыг дэмжин ажиллаж байна. |
| | 8-р зорилтын хүрээнд:<br>Иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах, хэвлэл мэдээллийн эрх зүйн | Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан Ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллаж байна. Тус газар нь төрийн үйлчилгээг ил тод, хариуцлагатай байдлаар явуулж, төрийн албыг төлөвшүүлэх чиглэлээр харьяа соёлын байгууллагуудад үүрэг чиглэл өгч ажиллаж байна. Салбарын шуурхай зөвлөгөөнийг |

| | | |
|---|---|---|
| | орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх; | 2018 оноос хойш 2 сар тутамд 1 удаа зохион байгуулан үүрэг чиглэл өгч ажиллаж хэвшсэн. |
| | 9-р зорилтын хүрээнд:<br>Улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагыг улс төр, бизнесийн бүлэглэлийн хууль бус ашиг сонирхол, нөлөөллөөс ангид байлгах; | Улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагыг улс төр, бизнесийн бүлэглэлийн хууль бус ашиг сонирхол, нөлөөллөөс ангид байлгах Төрийн албаны тухай хууль болон бусад хууль, тогтоомжийг мөрдлөг болгон ажиллаж байна. |
| | 10-р зорилтын хүрээнд<br>Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх; | Тус газраас авлигын эсрэг хууль, тогтоомж дүрэм журмыг сурталчилах, авлигыг үл тэвчихийг иргэн бүрт төлөвшүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх ажлын хүрээнд Авлигатай тэмцэх газраас www.iaav.mn цахим хуудсаар сэдэвчилсэн видео сурталчилгаа, контентыг өөрийн байгууллагын http://nsug.ub.gov.mn цахим сайтад байршуулан олон нийтэд түгээж сурталчилан ажилласан. Мөн ажилтан, албан хаагчдын цахим хаягаар сурталчилсан.<br><br>Тус газраас харьяа соёлын байгууллагуудын хүний нөөц, архив бичиг хэргийн ажилтнуудад зориулсан хууль эрх зүйн мэргэжил арга зүйн цахим сургалтыг 2020 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр онлайнаар зохион байгуулж, нийт 11 байгууллагын 16 албан хаагчид оролцсон.<br><br>Мөн Швейцарын агентлагийн санхүүгийн дэмжлэгээр Нийслэлийн засаг даргын тамгын газар, Азийн сантай хамтран хэрэгжүүлж буй “Хотын засаглалыг сайжруулах төсөл”-ийн хүрээнд Чанарын удирдлагын тогтолцоо болон Хууль эрх зүйн сэдэвт сургалтыг НЗДТГ-ын Сургалт сурталчилгааны төвөөс авахаар санал хүргүүлсэн боловч цар тахлын улмаас түр хугацаагаар хойшлоод байна.<br><br>Нийслэлийн Соёл, урлагийн газраас харьяа соёл, урлагийн байгууллагуудын албан хаагчдад зориулан “Төрийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй” сэдвээр болон Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комисстой хамтран “Хүний эрх”, “Жендэр”, “Хүний соёлын эрхийг хангахад соёл, урлагийн салбарын төрийн байгууллагын үүрэг оролцоо” сэдвээр сургалтыг 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн байранд зохион байгуулсан. Тус газрын харьяа соёлын байгууллагын нийт 30 гаруй албан хаагчид хамрагдав. |
| | 11-р зорилтийн хүрээнд<br>Авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд | Тус газраас “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх 2020 оны ажлын төлөвлөгөө”-г батлуулсан бөгөөд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс |

<table>
<tr><td></td><td colspan="2">олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын байгууллагын санал, зөвлөмжийг авч хэрэгжүүлэх;</td><td colspan="12">урьдчилан сэргийлэх тухай болон бусад холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлуудыг тусган хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.</td></tr>
<tr><td>7.</td><td colspan="2">Дүгнэлт /ололт, дутагдал, анхаарах асуудлууд/</td><td colspan="12">Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх 2020 оны ажлын төлөвлөгөө”-г батлуулж ажилласан.</td></tr>
<tr><td>8.</td><td colspan="2">Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ</td><td colspan="12"></td></tr>
<tr><td rowspan="2">9.</td><td rowspan="2">Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ,дүгнэлт (өөрийн үнэлгээ)</td><td>Биелэлтийн дундаж</td><td>Зорилтын тоо</td><td>Зорилт 1</td><td>Зорилт 2</td><td>Зорилт 3</td><td>Зорилт 4</td><td>Зорилт 5</td><td>Зорилт 6</td><td>Зорилт 7</td><td>Зорилт 8</td><td>Зорилт 9</td><td>Зорилт 10</td><td>Зорилт 11</td></tr>
<tr><td>80%</td><td>11</td><td>80%</td><td>80%</td><td>80%</td><td>80%</td><td>80%</td><td>80%</td><td>80%</td><td>80%</td><td>80 %</td><td>80%</td><td>80%</td></tr>
<tr><td rowspan="2">1 0.</td><td rowspan="2">Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)</td><td colspan="13">Нэгдсэн үнэлгээ</td></tr>
<tr><td colspan="13">%</td></tr>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
</table>

ХЯНАСАН:
ДАРГА Ж.ДАМДИНЦЭРЭН

БОЛОВСРУУЛСАН:
ХҮНИЙ НӨӨЦ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Б.МӨНГӨНТҮЛХҮҮР

ТТБ 5977

# НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2020 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2020 оны 12 дугаар сарын 16-ны өдөр | Улаанбаатар хот

| № | Зорилт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжилт | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1. | Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангах, зохион байгуулалтын шинэлэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх. | 1.1.1 Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөө боловсруулж батлуулах. | Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөг 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдөр боловсруулан баталсан. | |
| | | 1.1.2. Авлигаас урьдчилан сэргийлэх, хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлгийг үнэн зөв мэдүүлэхийн ач холбогдол, давуу талууд сэдэвт сургалт зохион байгуулах. | Тус газрын албан хаагчид Авлигаас урьдчилан сэргийлэх, хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлгийг үнэн зөв мэдүүлэхийн ач холбогдол, давуу талуудыг https://www.iaac.mn/ цахим хуудсаар мэдээ мэдээлэл гарын авлагыг судалж ажиллаж байна. | |
| 2.1. | Авлигын эсрэг хууль тогтоомж, бодлого шийдвэрийг иргэдэд сурталчлах, мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцлийг бүрдүүлэх. | 2.1.1.Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн тайланг цахим хуудсанд байрлуулах. | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдөр хэрэгжүүлэн ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталсан. | |
| | | 2.1.2.Авлигын эсрэг хийж буй ажлын мэдээллийг байгууллагын сайтад байрлуулж сурталчлах. | - Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын зөрчлийн талаар мэдээллийг тухай бүр www.shilendans.gov.mn шилэн дансанд оруулж ажиллаж байна.<br>- Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдлүүлэгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилож байна. Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын хавсралт" Төрийн захиргааны болон үйлчилгээний албан | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг мөрдлөг болгон байгууллагын сайтад байршуулан ажиллаж байна.<br>- Тус газрын хэмжээнд өргөдөл, гомдол, мэдээллийг цахим хэлбэрээр гаргах, шийдвэрлэх, хяналт тавьж, цаг тухай бүр шийдвэрлэж ажилласан. | |
| | | 2.1.3 Байгууллагын мэдээллийн самбарт авлигын эсрэг хууль тогтоомж, байгууллагаас үзүүлж буй төрийн үйлчилгээний нэр төрөл, холбогдох дүрэм, журам, албан хаагчдын мэдээлэл зэргийг цахим хуудас байршуулан шинэчилж байх. | Байгууллагын мэдээллийн самбарт авлигын эсрэг хууль тогтоомж, байгууллагаас үзүүлж буй төрийн үйлчилгээний нэр төрөл, холбогдох дүрэм, журам, албан хаагчдын мэдээлэл зэргийг цахим хуудас байршуулан шинэчилж ажилласан. | |
| | | 2.1.4. Газрын даргын шийдвэрийг байгууллагын сайтад тухай бүр шивж оруулж ил тод нээлттэй байдлыг хангах. | Газрын даргын шийдвэрийг www.shilendans.gov.mn тухай бүр шивж оруулж ил тод нээлттэй байдлыг хангаж ажиллаж байна. | |
| 2.2 | Хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах хадгалах мэдээлэх хяналт тавих ажлыг хуулийн дагуу зохион байгуулах. | 2.2.1.Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг гаргуулах, АТГ-т хүргүүлэх мэдүүлгийг хянасан дүгнэлтийг үндэслэн албан тушаалд томилох. | Тус газрын бүтцийн өөрчлөлтөөр удирдах албан тушаалд шинээр томилогдсон 1 албан хаагч, Б.Насанжаргалыг Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэгийг хүлээн авч дүгнэлтийг үндэслэн 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдөр томилсон. Мөн Хасхомыг 30 хоногийн хугацаанд дахин мэдүүлж баталгаажуулсан.<br>Тус газраас “Хасхом” гаргах албан тушаалтны жагсаалтаас хасах болон нэмэх саналтай албан тушаалтны судалгааг гаргаж хүргүүлсэн. Судалгаанд хасах саналтай 2, нэмэх саналтай 1 албан хаагчдын мэдээллийг 2020 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 01/01 тоот бичгээр НЗДТГ-т хүргүүлсэн. Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын 2 албан хаагчдын мэдүүлэгийг 2019 оны тайлан маягтын дагуу гаргаж 2020 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн 01/59 тоот албан бичгээр НЗДТГ-т хүргүүлэв.<br>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай төсвийн шууд захирагчийн байгуулсан үр дүнгийн гэрээнд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай болон бусад холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлуудыг тусгасан. | |
| | | 2.2.2.Хувийн ашиг сонирхлын зөрчилгүй болон орлогын мэдүүлэг, их хэмжээний өөрчлөлтийг хуулийн хугацаанд нь гаргуулж авах, хяналт тавьж тайлагнах. | Хувийн ашиг сонирхлын зөрчилгүй болон орлогын мэдүүлэг, их хэмжээний өөрчлөлтийг хуулийн хугацаанд нь гаргуулж авах, хяналт тавьж тайлагнан ажиллаж байна. Хөрөнгө, орлогын мэдүүлгийн https://meduuleg.iaac.mn цахим системд УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын дагуу 2019 оны 2 дугаар сард байгууллагаас нийт 3 мэдүүлэг гаргагч мэдүүлгээ мэдүүлж, баталгаажуулсан бөгөөд хугацаанд нь 100%-тай тайлагнаж ажилласан. | |
| | | 2.2.3. Эрх бүхий албан тушаалтны гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарьт тусгах, хувь хүний нууцтай холбогдох мэдээллийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хангах. | Эрх бүхий албан тушаалтны гүйцэтгэх чиг үүргийг албан тушаалын тодорхойлолт, ажил үүргийн хуваарьт тусгах, хувь хүний нууцтай холбогдох мэдээллийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хангаж ажиллаж нууцын баталгаа гаргаж ажилласан. Мөн байгууллагуудын нэгж хоорондын уялдаа холбоог сайжруулах зорилгоор чиг үүргийн хуваарилалтад дүн шинжилгээ хийж, тус газрын даргын 2019 оны “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах тухай” А/09, “Албан тушаалын тодорхойлолтод дүн шинжилгээ хийх ажлын хэсэг байгуулах тухай ”А/22 тоот шийдвэрийн дагуу ажилласан ажлын хэсгийн бүрэлдэхүүн Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын дагуу 12 албан тушаалын тодорхойлолтын төслийг боловсруулж, томилох эрх бүхий этгээд “Хяналтын хуудас”-ын дагуу хянаж, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн, Нийслэл дэх Төрийн албаны салбар зөвлөлөөр хянуулж, Төрийн албаны зөвлөлөөр батлуулсан. | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2.3 | Ажлын байран дахь ашиг сонирхлын зөрчил үүсэх, эрсдлийг бууруулах. | 2.3.1 Ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэл бүхий албан тушаалтны жагсаалт гаргах. | Ашиг сонирхлын үүсэх эрсдэл бүхий албан тушаалтны мэдээллийг тус газраас "Хасхом" гаргах албан тушаалтны жагсаалтаас хасах болон нэмэх саналтай албан тушаалтны судалгааг гаргаж хүргүүлсэн. Судалгаанд хасах саналтай 1, нэмэх саналтай 1 албан хаагчдын мэдээллийг хүргүүлсэн. | |
| | | 2.3.2 Байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, авлигын эсрэг хамтын ажиллагааг сайжруулж, нийт ажилтан, албан хаагчдыг авлигаас ангид хамт олон болох уриалга гаргаж, байгууллагын сайтад байршуулж олон нийтэд сурталчилж ажиллах. | Тус газрын http://nsug.ub.gov.mn цахим хуудсаар хэрэгжүүлсэн ажил, мэдээ мэдээллийг цаг тухайд нь нээлттэй мэдээлж, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангаж ажилласан. Тус газраас авилгын эсрэг хууль, тогтоомж дүрэм журмыг сурталчлах, авилгыг үл тэвчихийг иргэн бүрт төлөвшүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх ажлын хүрээнд Авилгатай тэмцэх газраас www.iaac.mn цахим сайтаас сэдэвчилсэн видео сурталчилгаа, контентыг өөрийн байгууллагын http://nsug.ub.gov.mn цахим сайтад байршуулан олон нийтэд түгээж сурталчилан ажилласан. Мөн ажилтан, албан хаагчдын цахим хаягаар сурталчилсан. | |

ХЯНАСАН:
ДАРГА Ж.ДАМДИНЦЭРЭН

БОЛОВСРУУЛСАН:
ХҮНИЙ НӨӨЦ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Б.МӨНГӨНТҮЛХҮҮР